

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ ХОРИНТАВДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2016 оны есдүгээр сарын 1-ний 14 цаг 05 минутад эхэлж, 16 цаг 31 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 2 цаг 26 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Гадаад харилцааны яамны Бодлого, төлөвлөлтийн газрын захирал, Америк, Ойрхи дорнод, Африкийн газрын захирал, Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын захирал, Төрийн захиргааны удирдлагын газрын захирал, Консулын газрын захирал, Дипломат ёслолын газрын захирал, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын захирал зэрэг албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах комиссын 13 дугаар дүгнэлтүүдийг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн:</p> <p>Шижээхүүгийн Одонбаатарыг Гадаад харилцааны яамны Бодлого, төлөвлөлтийн газрын захирлын, В.Энхболдыг тус яамны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын захирлын, Н.Анхбаярыг мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын захирлын, Я.Ариунболдыг тус яамны Консулын газрын захирлын, Ц.Мөнх-Өлзийг уг яамны Дипломат ёслолын газрын захирлын, Б.Баярсайханыг мөн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын захирлын албан тушаалд тус тус томилуулахаар нэр дэвшүүлж, Гадаад харилцааны яаманд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөл тогтоол гаргахаар тогтов.</p>

2	<p>Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах комиссын 14 дүгээр дүгнэлтийг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдаанаас:</p> <p>Энхбаатарын Бат-Идэрийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Ш.Солонгод санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөл тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газрын дэд даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “б”-д заасныг тус тус баримталж, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах комиссын 22 дугаар дүгнэлтийг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдаанаас:</p> <p>Дэмбэрэлсүрэнгийн Түвшинтөрийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газрын дэд даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогтод санал болгох тухай Монгол Улсын Төрийн</p>

		албаны зөвлөл тогтоол гаргахаар тогтов.
4	Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ажлын албаны Шүүхийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “б”-д заасныг тус тус баримталж, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах комиссын 23 дугаар дүгнэлтийг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдаанаас</p> <p>Ж.Сайнхишигийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ажлын албаны Шүүхийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Т.Мэндсайханд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөл тогтоол гаргахаар тогтов.</p>
5	Ерөнхий сайдын зөвлөхөөр ажиллаж байсан Р.Булгамааг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17.11, Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоол, иргэн Р.Булгамаагийн хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөхөөр 2015 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс 2016 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хооронд томилогдон ажиллаж байсан Ринзааны Булгамааг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөл тогтоол гаргахаар тогтов.</p>
6	"Төрийн албаны зөвлөлийн салбар	Төрийн албаны тухай хуулийн 35

	<p>зөвлөлийн ажиллах журам"-д өөрчлөлт оруулах тухай</p>	<p>дугаар зүйлийн 35.1.3, “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн.</p> <p>Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.4 дэх заалтын “хэрэгжүүлэгч” гэсний өмнө “Үндэсний статистикийн хороонд тус хорооны дарга,” гэж нэмэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөл тогтоол гаргахаар тогтов.</p>
7	<p>Үндэсний статистикийн хорооны дэргэд Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл байгуулж, бүрэлдэхүүнийг батлах, Салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргыг томилох тухай</p>	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Үндэсний статистикийн хорооны дэргэдэх Салбар зөвлөлийг 2016 оны 08 дугаар сарын 25-ны өдрөөс дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулах. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Үндэсний статистикийн хорооны дарга /Салбар зөвлөлийн дарга/ 2. Тамгын газрын дарга, 3. Статистикийн эрдэм шинжилгээ, арга зүйн газрын дарга, 4. Нийгмийн статистикийн газрын дарга 5. Эдийн засгийн статистикийн газрын дарга 6. Дотоод аудитын хэлтсийн дарга, 7. Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн даргыг /Салбар зөвлөлийн нарийн

		<p>бичгийн дарга/ 2. Үндэсний статистикийн хорооны дэргэдэх Салбар зөвлөлийг арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Орон тооны гишүүн С.Цэдэндамбад үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөл тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3, "Үндэсний статистикийн хорооны даргыг томилох тухай" Улсын Их Хурлын 2016 оны 21 дүгээр тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн :</p> <p>1. Үндэсний статистикийн хорооны дарга Аюушийн Ариунзаяаг 2016 оны 08 дугаар сарын 25-ны өдрөөс Төрийн албаны зөвлөлийн тус хорооны дэргэдэх салбар зөвлөлийн даргаар томилох</p> <p>"Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн дарга А.Ариунзаяад үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөл тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах</p>
--	--	---

		<p>журам"-ын 1.4 дэх заалтыг баримтлан Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <ol style="list-style-type: none">1. Үндэсний статистикийн хорооны Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга Шаравсэнгийн Оюунгэрэлийг Төрийн албаны зөвлөлийн тус хорооны дэргэдэх салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар 2016 оны 08 дугаар сарын 25-ны өдрөөс томилох2. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Ш.Оюунгэрэлд үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөл тогтоол гаргахаар тогтов.
--	--	---

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА